



2021.11.17

Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. Зөрчлийн тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээг:

Нэг талаас Сэлэнгэ аймаг Сайхан сумын "Засаг даргын Тамгын газар" гэх /төлөөлж/ Хууль зүй хариуцсан мэргэжилтэн Б.Хэрлэнтунгалаг негee талаас "Түмэнзүл энержи" ХХК-ийг төлөөлж захирал албан тушаалтай А.Отгонсурэн нар нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.3 "б", 29.1.3 "е", 29.1.3 "н" дэх заалтуудыг тус тус үндэслэн дор дурьдсан нэхцелүүдийг хэлэлцэн тохиролцож энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид "гэрээ" гэх-г байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагааг сумын нийгэм, здийн засгийн хөгжилд оруулах нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх тогтвортой бичил уурхайг хөгжүүлэхэд оршино.

Хоёр. Уул уурхайн аж, ахуй нэгж байгууллагын хүлээх үүрэг

- 2.1. Сайхан сумын Номгон тосгон, Овоот, Дөмбөн, Жимстэй хорооллын автозамыг сайжруулах хатуу хучилттай болгох бүтээн байгуулалтын ажилд 20,000,000 /хорин сая/ төгрөгтэй дүйцэх хэмжээний ажил үйлчилгээ үзүүлнэ.
- 2.3. Тусгай зөвшөөрөл зээмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нэхцэл болон тухайн газарт амьдарч байгаа иргэдийн аюулгүй байдал хангах
- 2.4. Орон нутгийн 5-10 иргэнийг ажлын байраар хангах
- 2.5. Уул уурхайн ил тод байдлыг хангах
- 2.6. Сайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид сар бүр тухайн орд газрынхаа неец болон олборлолт явуулсан мэдээ тайланг ирүүлж байх
- 2.7. Эвдрэлд орсон газрын байгаль орчныг нэхэн сэргээх, мод, бут, сеөг, олон наст ургамал тарих

Гурав. Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг

3.1. Сумын нутаг дэвсгэр дээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д үндсэн үйлдвэрлэлээс гадна бусад ажил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.

3.4. Сумаас уурхайн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл солилцно.

Дөрөв. Хамтран хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд

4.2. Суманд хэрэгжих томоохон тесэл /орон сууц, зам гүүр, дэд бүтэц гэх мэт/ хэрэгжүүлэхэд хамтран оролцох

4.3. Бичил, жориг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах

4.5. Уул уурхайн сургалт, дадлага хийхэд хамтран ажиллана

Тав. Бусад болон Хариуцлага

5.1. Хуулиар болон гэрзэгээр хулэсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй улсын байцаагчийн тавьсан шаардлагыг үл хүндэтгэсэн тохиолдолд ААНБ-ын тусгай зөвшөөрлийг холбогдох газарт уламжилж цуцлах хүртэл арга хэмжээ авах болно.

5.2. Энэхүү гэрзэг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаагаар байгуулав.

5.3. Дээрхи гэрзэг жил бүр тогтмол дүгнэж байх бөгөөд гэрзэний аль нэг тал үүрэгт ажлаас чөлөөлгэдсэн нь гэрзэг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН:

Г.Хүрэл

Б.ХЭРЛЭНТҮНГАЛАГ

ТҮМЭНЗУЛ ЭНЕРЖИ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

